



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/496

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дугаар зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Толхын ойлын 1, 2 дугаар байрны гадна шугам сүлжээ шинэчлэх ажилд зориулан 9 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 9 000 000 /Есөн сая / төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтанд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.14-д Хуучирч муудсан шугам сүлжээний засвар үйлчилгээ /Жаргалант сум/-с санхүүжүүлж ажиллахыг Ховд Хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал /Т.Мягмардорж/, нягтлан бодогч /С.Оюунжаргал/ нар зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/490 Ch  
02 02200